



БОГД БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИ

БОГД БАНКНЫ ТОС-ЫН АЖЛЫН ХЭСЭГ

2023

3-Р УЛИРЛЫН ТАЙЛАН



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

Богд Банк нь байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагаа ухамсарласан, ил тод үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэдэг билээ. Бид өөрсдийн санхүүжүүлэх төсөлд ч энэхүү шалгуурыг тавьж, дэмжин ажилладаг бөгөөд уг зорилгын хүрээнд Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн (ТоС) хөтөлбөрт нэгдэн орж, 2015 оноос ТоС хөтөлбөрийн албан ёсны гишүүнээр элсэн орсон. Түүнээс хойш Богд банк өдөр тутмын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээндээ тогтвортой хөгжлийн зорилтуудыг үргэлж тусгаж ирсэн.



НОГООН ОРЧИН I

Богд банк ХК, Бодь Даатгал ХК болон Богд цамхаг хамтран “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Гачууртын Их Дэндий аманд 1000 хайлаасны суулгац тарилаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдсэн бөгөөд салбарын хэмжээнд ирэх 2030 он хүртэл 50 сая мод тарих амлалтын хүрээнд 2022 оны 10 сарын 19-ний өдөр Гачууртын Их Дэндий аманд 140 улиас, 40 нарс, 1 гацуур болон 1 шинэс модны суулгац тарьж үржүүлж өөрсдийн төглийг байгуулж байсан билээ.

Сүүлийн жилүүдэд байгалийн гамшигт үзэгдэл, түүний эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөлөл нэмэгдэж, эдийн засгийн тогтвортой өсөлтөд эрсдэл учирч байгаа энэ үед нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр Монголын банкны холбооноос зохион байгуулдаг нэгдсэн мод тарих аян болон өөрсдийн төгөлд мод тарьж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үйл ажиллагааг дэмжин ажилласаар байна.



НОГООН ОРЧИН 2

“Тэрбум мод сан”-гийн санхүүжүүлэгч арилжааны банкнуудыг төлөөлөн БОГД БАНК нь 112-р цэцэрлэгийн хичээлийн шинэ жилд оролцлоо.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих зорилгоор Монголын банкны холбооны санаачилгаар арилжааны банкнууд хамтран Монголбанкны дэмжлэгтэйгээр Тэрбум мод санг байгуулж, анхны төслийн нээлттэй сонгон шалгаруулалтад тэнцсэн төслүүдийг өнгөрсөн 5 сард зарласан билээ.

Уг төслийн 1-р чиглэлийн хүрээнд буюу Улаанбаатар хотын сургууль, цэцэрлэгийн ногоон байгууламжийг сайжруулах, хүүхдийн сурах орчныг эрүүл болгоход хувийн хэвшлийн төлөөллүүд хувь нэмэр оруулж, энэ жил нийт 9 сургууль, 11 цэцэрлэгийн гадаа орчныг цэцэрлэгжүүлээд байна. Ногоон байгууламжийн ажлыг шалгарсан мэргэжлийн гурван байгууллага зуны гурван сар хийж гүйцэтгэн, сурагч хүүхдүүдээ угтан авахад бэлэн болжээ.

Шалгарсан төслүүдээс төлөөлөн Богд банк нь Сонгинохайрхан дүүргийн 112-р цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн нээлтэд оролцсон бөгөөд төслийн хүрээнд 112-р цэцэрлэгт 700 мод, 300м2 зүлэгжүүлэлт, 50м2 цэцгийн мандал, 4х3 м2 хэмжээтэй хүлэмжийг байгуулсан. Энэхүү төслөөр бид хүүхэд залуучуудын сурах орчныг эрүүл болгох, багш, сурган хүмүүжүүлэгч, сурагч, эцэг эхчүүдийн дунд мод тарих, арчилж хамгаалах аргачлал, ач холбогдлын талаарх мэдлэг ойлголт нэмэгдүүлж, цаашид үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх арвин үйлсэд арилжааны банкнууд хамтран хувь нэмрээ оруулж байгаадаа таатай байна.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Богд банк нь Тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан бизнесийн зээл”, “Бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих зээл”, “Ногоон хэрэглээний зээл”, “Эко автомашины зээл” болон “Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй батлан даалттай төслийн зээл”-ийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэн Тогтвортой санхүүжилтийг дэмжин ажиллаж байна.

